



Ректорын 2011 оны...-р сарын ... өдрийн
тоот тушаалын хоёрдугаар хавсралт

**ШУТИС-ИЙН МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТТАЙ БҮРЭЛДЭХҮҮН СУРГУУЛЬ,
КОЛЛЕЖ, МСҮТ-Д СУРАЛЦАГЧДЫН МЭРГЭЖЛИЙН ДАДЛАГА ХИЙХ ЖУРАМ**

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, техникийн боловсрол, мэргэжлийн сургалтыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр, бусад хууль эрхийн актуудтай уялдуулан ШУТИС-ийн мэргэжлийн сургалттай бүрэлдүүн сургууль, коллеж, МСҮТ-д суралцагчдын суралцах хугацааны сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан мэргэжлийн дадлагыг зохион байгуулахад энэхүү дүрмийг мөрдөнө.

1.2. Мэргэжлийн дадлага сургалтын төлөвлөгөөнд заасны дагуу сургууль дээр хийгдэх үйлдвэр, сургалтын дадлага, аж ахуйн нэгж, байгууллага, компаниуд дээр хийгдэх үйлдвэрлэлийн болон, төгсөлтийн өмнөх дадлага гэсэн хэлбэртэй байна.

ХОЁР. Үйлдвэр сургалтын дадлага

2.1. Үйлдвэр, сургалтын дадлага гэж тухайн мэргэжлийн дагуу онолоор үзсэн мэдлэгээ дадлагын багшийн удирдлага, зааварчлагын дагуу сургууль дээрхи тусгай тоноглогдсон лаборатори, дадлагын газарт хийх сургалтыг хэлнэ.

2.2. Сургууль дээр үйлдвэр, сургалтын дадлага явагдах лаборатори, дадлагын газар нь хөдөлмөр, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны нөхцлийг хангасан, тухайн мэргэжлийг эзэмшихэд шаардагдах техник, технологи, тоног төхөөрөмж, багаж, хэрэгслэлээр иж бүрэн тоноглогдсон байна.

2.3. Үйлдвэр, сургалтын дадлагын газар нь эмнэлэгийн анхны тусламж үзүүлэх эмийн сан, хөдөлмөр, аюулгүй ажиллагааны дүрмийн булантай байх бөгөөд дадлагын багш хичээл эхлэхийн өмнө зааварчлагаа өгч, гарын үсэг зуруулсан байна.

2.4. Үйлдвэр, сургалтын дадлагыг сургалтын төлөвлөгөөний дагуу суралцагчдыг аль болохоор мэргэжилдээ дур сонирхолтой болгох, тэдний бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглүүлэн явуулна.

2.5. Сургуулийн захиргаа үйлдвэр, сургалтын дадлагын хичээл явуулахад шаардагдах сургалтын материал, багаж хэрэгслээр бүрэн хангах бөгөөд суралцагчдаас эдгээрт шаардагдах зардлыг хураан авахыг хориглоно. Харин суралцагч өөрөө хүсэлт тавьж материалаа гарган дадлагын хичээлээрээ тодорхой бүтээл хийж өөрийн хэрэгцээнд авахыг зөвшөөрч болно.

2.6. Дадлагын хичээлээр гүйцэтгэх ажлын нөхцлөөс хамааруулан хөдөлмөр хамгааллын тусгай хувцсыг суралцагчид болон эцэг, эхтэй зөвшилцсөний үндсэн дээр зардлыг нь гаргуулж сургуулийн захиргаанаас нэгдсэн журмаар нэг загврын хувцас хийлгэж хангана.

ГУРАВ. Үйлдвэрлэлийн дадлага

3.1. Үйлдвэрлэлийн дадлага гэж сургалтын төлөвлөгөөнд заасны дагуу тухайн мэргэжлийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, үйлдвэр газар дээр хийх урт хугацааны дадлагыг хэлнэ.



Ректорын 2011 оны...-р сарын ... өдрийн
тоот тушаалын хоёрдугаар хавсралт

3.2. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд суралцагчдийг идэвхтэй оролцуулах, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, зохион байгуулалт, техник технологи, хөдөлмөрийн үйл ажиллагааны арга барилыг судлуулах, тэдний танхимийн сургалтаар эзэмшсэн онолын мэдлэг, чадвараа үйлдвэрлэл дээр бататган гүнзгийрүүлж, мэргэжлийн өндөр ур чадвар эзэмшүүлэхэд үйлдвэрлэлийн дадлагын зорилго оршино.

3.3. Сургуулийн захиргаа үйлдвэрлэлийн дадлага хийлгэх аж ахуйн нэгж байгууллага, үйлдвэрийн газрын захиалга, саналыг үндэслэн суралцагчдыг хуваарилан, дадлагын хугацаанд судлаж мэдэх, хийж гүйцэтгэх ажлыг тусгасан удирдамж, төлөвлөгөө гаргаж, дадлага удирдах багшийг томилон ажиллуулна.

3.4. Шаардлагатай гэж үзвэл дадлага хийлгэж байгаа газрын тухайн мэргэжлийн инженер, мэргэжилтнүүдээр үйлдвэрлэлийн дадлагыг удирдуулж болох бөгөөд энэ тохиолдолд тухайн хүнтэй гэрээ байгуулж, дадлага удирдах хүүхдийн тооноос хамааруулан гэрээт багшийн нэгэн адилаар хөлсийг тооцон олгоно.

3.5. Үйлдвэрлэлийн дадлага хийлгэх тухай сургуулийн захиргаа, дадлага хийлгэх газрын удирдлага, суралцагчдын хооронд гурвалсан гэрээ байгуулах бөгөөд уг гэрээнд гурван талын хүлээх үүрэг хариуцлагыг тодорхой тусгасан байна.

3.6. Суралцагч үйлдвэрлэлийн дадлага хийх аж ахуйн нэгж, байгууллагатай тохиролцон гэрээ байгуулж, түр ажилчнаар орж дадлагаа цалинтай хийж болох бөгөөд энэ тохиолдолд тухайн байгууллагын дүрэм, дотоод журам, ажлын цагийг үндсэн ажилчдын нэгэн адилаар дагаж мөрдөнө. Харин 18 нас хүрээгүй хүүхдийг эцэг, эх, асран хамгаалагчдын зөвшөөрлөөр гурвалсан гэрээ байгуулж ажиллуулна.

3.7. Үйлдвэрлэлийн дадлагын явцыг сургуулиас томилогдсон тухайн мэргэжлийн багш байнга хянаж, удирдамжийн дагуу чанартай явагдаж байгаа эсэх болон дадлага хийж байгаа суралцагчдын санал хүсэлтийг холбогдох хүмүүст хүргэж дадлагаа мэргэжлийн дагуу чанартай хийхэд туслана.

3.8. Сургуулийн захиргаа дадлагад гарсан суралцагчийн ажлын хөлснөөс суутгаж авах, дадлагын суралцагч ажиллуусны төлөө тухайн байгууллагаас төлбөр, хандив нэхэж авахыг хориглоно.

ДӨРӨВ. Төгсөлтийн өмнөх дадлага

4.1. Төгсөлтийн өмнөх дадлага гэж тухайн мэргэжлээр суралцах хугацаанд эзэмшсэн мэдлэг, чадвар, дадлага бататгаж, мэргэжлийн зэргээ тогтоохоор аж ахуйн нэгж, байгууллага дээр суралцсан мэргэжлийн чиглэлээр хийх дадлагыг хэлнэ.

4.2. Суралцагчдыг аж ахуйн нэгж, байгууллага дээр бие даан ажиллуулж тухайн мэргэжлээр суралцах хугацаанд олж авсан онолын мэдлэг, эзэмшсэн мэргэжлийн ур чадвар, чадамжийг бататган, мэргэжлийн зэргийн түвшнийг урдчилан тогтооход төгсөлтийн өмнөх дадлагын зорилго оршино.

4.3. Сургуулийн захиргаа суралцагчдын саналаар өмнө нь үйлдвэрлэлийн дадлага хийсэн аж ахуйн нэгж байгууллага, эсвэл төгсөөд ажиллах ажлын байранд нь төгсөлтийн өмнөх дадлага хийлгэх удирдамж, хөтөлбөр гарган баталж дадлагын явцад хяналт тавих сургуулийн төлөөллийг томилж ажиллуулна.

4.4.Сургуулийн захиргаа, үйлдвэр аж ахуйн нэгж, байгууллагатай тохиролцон төгсөлтийн өмнөх дадлагыг хариуцан ажиллах мэргэжлийн инженер, техникийн ажилтнуудыг томилон гэрээ байгуулан ажиллуулж, хүүхдийн тооноос хамааруулан энэ журмын 3.4-д заасны дагуу хөлс олгоно.

4.5.Төгсөлтийн өмнөх дадлага хийлгэсэн үйлдвэр, аж ахуйн газар, байгууллага дадлагыг удирдан хариуцаж ажилласан хүний санал дээр үндэслэн тухайн суралцагчийн дадлага хийсэн байдал, эзэмшсэн мэргэжлийн ур чадвар, чадамжийг үнлэн мэргэжлийн хэд дүгээр зэргийн болзол хангаж байгааг тогтоон тодорхойлолт гаргаж өгнө. Энэ нь тухайн суралцагчид мэргэжлийн зэрэг олгох нэг үзүүлэлт болно.

4.6.Төгсөлтийн өмнөх дадлага хийхэд энэ дүрмийн 3.6, 3.7, 3.8 заалтууд нэгэн адил мөрдөгдөнө.

ТАВ.Дадлагын үнэлгээ

5.1.Үйлдвэр сургалтын дадлагыг сургуулийн сургалтын албанаас мэргэжлийн модуль тус бүрээр сорилын ажил хийлгэж, улирал бүр мэргэжлийн ур чадвар, чадамжийн шалгалт авч дүгнэнэ.

5.2.Үйлдвэрлэлийн дадлагыг сургуулийн захиргаанаас томилогдсон комисс суралцагч нэг бүрээр дадлагын хугацаанд хийж гүйцэтгэсэн ажил, сурч мэдсэн шинэ технологи, техник, тоног төхөөрөмж, эзэмшсэн мэргэжлийн ур чадвар, чадамж, онолын сургалтыг үйлдвэрлэл дээр хэрхэн бататгасан, дадлагын явцад гарсан ололт, дутагдал, санал, бодол зэргийг багтаасан тайлан хамгаалуулж дүгнэнэ.

5.3.Үйлдвэрлэлийн дадлагыг удирдамж, хөтөлбөрийн дагуу хийгээгүй, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр дутуу хийсэн, тасалсан, тайланг хангалтгүй хамгаалсан суралцагчыг нөхөж хийлгүүлнэ.

5.4.Төгсөлтийн өмнөх дадлагыг ШУТИС-ийн ректорын тушаалаар томилогдсон төгсөлтийн шалгалт авах, мэргэжлийн зэрэг олгох комисс төгсөгч нэг бүрээр дадлагын тайлан хамгаалуулж дүгнэнэ. Энэ нь төгсөгчид мэргэжлийн зэрэг олгох нэг шалгуур үзүүлэлт болно.